



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2020/177/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баян-Өлгий аймаг, Өлгий сум
2020 он

Тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70429254 Цахим хаяг:
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг:
Аудитор: Р.Баярмаа
Утас: 99265539 Цахим хаяг: Bayarmaa327@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14



2.1. Оршил

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч М.Алтынай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 23-аас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 0/15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд эрүүл таатай орчинд өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах, бусдаасаа суралцах сонирхлыг бий болгох”-д оршино.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн тайлант онд “Хүүхдийг бие даан тоглох мэдлэгээ бүтээлчээр ашиглахад суралцуулах, юмсыг ашиглан учир шалтгааныг нь олж мэддэг болгох, бусдыг хүндэтгэх, тэдэнд туслах, өөрийн хэм хэмжээнд асуудлыг шийдвэрлэдэг болгох, өөрөө өөртөө үйлчлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеэ авч явах чадвартай болгох” гэсэн зорилго, зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Тус цэцэрлэг нь Аймгийн Засаг даргын 2019 оны 8 дугаар 8-ны өдрийн А/572 дугаар захирамжаар үүсгэн байгуулагдаж, сумын 1дүгээр цэцэрлэгийн хуучин байранд байрлаж 11, 12 дугаар сард үйл ажиллагаагаа явуулсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Аколоус” программ хангамж ашигладаг байна.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 27 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн Нийт зардал-г сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэх үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 80311,5 мянган төгрөгөөс тооцон 1606,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 31440, мянган төгрөг байна.

Тайлант оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		36,5	36,5
Урьдчилгаа			
Бараа материал		15326,2	25326,2
Үндсэн хөрөнгө		6077,4	6077,4
Нийт хөрөнгө		21440,2	31440,2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		21440,2	21440,2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		21440,2	21440,2

Бараа материалын дансны үлдэгдэл аж ахуйн материал, бусад хангамжийн материал, хүнсний материал, бичиг хэргийн дансны үлдэгдэл байна. Тайлант онд 32329,2 мянган төгрөгийн материалыг худалдан авч, сумын орлогын давсан хэсгээс 10000,0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч аж ахуйн материал дансанд орлогод авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6077,4 мянган төгрөг ба төсвийн хөрөнгөөр 5197,4 мянган төгрөгөөр компьютер, тоног төхөөрөмж, 880,0 мянган төгрөгийн санхүүгийн программ хөрөнгийг худалдан авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 21440,2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 31440,2 мянган төгрөгийн үр дүнтэй гарсантай холбоотой.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” гэсэн 1 төсөл хөтөлбөрт зориулан 91751,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 91751,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 82061,7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 9690,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Гүйцэтгэлээр төсвөөс 91751,7 мянган төгрөгийн санхүүжилт авч 90884,5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 99,1 хувьтай гарсан байна. Энэ нь цалингийн зардлаас 867,2 мянган төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын 50949,2 мянган төгрөг буюу 56,1%-ийг цалин болон НДШ-ийн зардалд, 9690,0 мянган төгрөг буюу 10,7%-ийг байр ашиглалтын зардалд, 7133,9 мянган төгрөг буюу 7,8%-ийг хангамж бараа материалын зардалд, 18055,9 мянган төгрөг буюу 19,9%-ийг нормативт зардалд, 669,6 мянган төгрөг буюу 0,7%-ийг томилолт, зочны зардалд, 251,2 мянган төгрөг буюу 0,3%-ийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 4134,7 мянган төгрөг буюу 4,5%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулжээ.

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд батлагдсан орон тооноос 2 орон тоогоор илүү үйл ажиллагаа явуулсан байна. Энэ нь эмч, бэлтгэгч гэсэн орон тоонд илүү хүн авч ажиллуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсөв аваагүй байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 27 эрсдэл тодорхойлж, горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх залруулагдаагүй алдаа зөрчил илрээгүй ба зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв. Санхүүгийн тайланд 10000,0 мянган төгрөгийн залруулга хийгдлээ. Үүнд:

1.Тус цэцэрлэгийн байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа тус сумын 1 дүгээр цэцэрлэгийн хуучин байранд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10000,0 мянган төгрөгөөр хийгдсэн засварын дүнгээр 10000,0 мянган төгрөгийг аж ахуйн материал дансанд орлого авч, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь УСНББОУС 12 Бараа материал.

Бараа материалд дараах хөрөнгө орно:

(а) Үйлдвэрлэлийн процесст ашиглагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа.

(б) Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материала буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа.

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 4.15, 4.21 дэх заалтууд болон санхүүгийн тайлангийн холбогдох батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул Санхүүгийн байдлын тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Бараа материалын тодруулга тайлангуудад тус тус залруулга хийгдлээ.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлтэй гэж сонгосон дансуудад түүврийн аргаар горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд төсвийн хөрөнгийн зарцуулалтыг гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг нь 2019 оны 11 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба аудитад анх удаа хамрагдсан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

1.Тайлант хугацааны ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт:

- *Холбогдох стандартын шаардлага хангасан, байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгасан, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж ашиглаагүй байна.*

1.2. Эрсдэл:

- *Байгууллагын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд буруу илэрхийлэгдэх, баримтлах бодлого арга зүйгүй ажиллах*

1.3. Өгсөн зөвлөмж:

- *Холбогдох стандартын шаардлага хангасан, байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгасан, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, байгууллагын даргын тушаалаар баталж, ашиглах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			СТ-1А
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	25362754.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	2.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	2.00
3121	Төгрөг	0.00	2.00
31213	Арилжааны банк дахь харилцах		2.00
33	АВЛАГА	0.00	36509.73
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		36509.73
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	25326242.50
354	Хангамжийн материал	0.00	25326242.50
35410	Бичиг хэргийн материал		103600.00
35420	Аж ахуйн материал		16513000.00
35440	Түлш, шатах тослох материал		2396000.00
35460	Хүнсний материал		1255642.50
35470	Бусад хангамжийн материал		5058000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	6077400.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	6077400.00
392	Биет хөрөнгө	0.00	5197400.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		5197400.00
393	Биет бус хөрөнгө	0.00	880000.00
39301	Програм хангамж		880000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	31440154.23
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	31440154.23
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	31440154.23
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	31440154.23
51220	Тайланг үеийн үр дүн		31440154.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	31440154.23

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН				СТ-2А
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	111751702.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	20000002.00	
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	20000002.00	
120002	Хүүгийн орлого		2.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	20000000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		20000000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	91751700.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	82061700.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		82061700.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	9690000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		9690000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	80311547.77	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	80311547.77	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	79444347.77	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	45748490.27	
210101	Үндсэн цалин		40503190.27	
210104	Урамшуулал		5245300.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	5164200.00	
210201	Тэтгэврийн даатгал		3511800.00	
210202	Тэтгэмжийн даатгал		413200.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал		330500.00	
210204	Ажилгүйдлийн даатгал		82500.00	
210205	Эрүүл мэндийн даатгал		826200.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	7294000.00	
210301	Гэрэл, цахилгаан		450000.00	
210302	Түлш, халаалт		6844000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	11757700.00	
210401	Бичиг хэрэг		479100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		243100.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		11035500.00	
2105	Нормативт зардал	0.00	8711357.50	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		67000.00	
210502	Хоол, хүнс		8644357.50	
2107	Томилолт, зочны зардал	0.00	669600.00	
210702	Дотоод албан томилолт		669600.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	99000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		99000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	867200.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	867200.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		867200.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	31440154.23	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	31440154.23	

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН				СТ-2А
				/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	91751702.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	2.00	
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	2.00	
120002	Хүүгийн орлого		2.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	91751700.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	82061700.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		82061700.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	9690000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		9690000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	85674300.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	85674300.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	84807100.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	45785000.00	
210101	Үндсэн цалин		40539700.00	
210104	Урамшуулал		5245300.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	5164200.00	
210201	Тэтгэврийн даатгал		3511800.00	
210202	Тэтгэмжийн даатгал		413200.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал		330500.00	
210204	Ажилгүйдлийн даатгал		82500.00	
210205	Эрүүл мэндийн даатгал		826200.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	9690000.00	
210301	Гэрэл, цахилгаан		450000.00	
210302	Түлш, халаалт		9240000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	3175300.00	
210401	Бичиг хэрэг		83700.00	
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр		243100.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2848500.00	
2105	Нормативт зардал	0.00	18055900.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		67000.00	
210502	Хоол, хүнс		9900000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		8088900.00	
2107	Томилолт, зочны зардал	0.00	669600.00	
210702	Дотоод албан томилолт		669600.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	31400.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		31400.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2235700.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2235700.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	867200.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	867200.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		867200.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	6077402.00	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	6077400.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	6077400.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	6077400.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		6077400.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-6077400.00	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	2.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			2.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						СТ-4А
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН						
						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайланг үеийн үр дүн					0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайланг үеийн үр дүн			31,440,154.23		31,440,154.23
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	31,440,154.23	0.00	31,440,154.23

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН					ТГ
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
		/ төгрөгөөр /			
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	91751700.00	90884500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	91751700.00	90884500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	91751700.00	90884500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	46652500.00	45785000.00
210101	Үндсэн цалин			41407200.00	40539700.00
210102	Нэмэгдэл			5245300.00	
210104	Урамшуулал				5245300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	5164200.00	5164200.00
210201	Тэтгэврийн даатгал			3511800.00	3511800.00
210202	Тэтгэмжийн даатгал			413200.00	413200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			330500.00	330500.00
210204	Ажилгүйдлийн даатгал			82500.00	82500.00
210205	Эрүүл мэндийн даатгал			826200.00	826200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	9690000.00	9690000.00
210301	Гэрэл, цахилгаан			450000.00	450000.00
210302	Түлш, халаалт			9240000.00	9240000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	7133600.00	7133900.00
210401	Бичиг хэрэг			585900.00	585900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр			250200.00	250500.00
210404	Ном, хэвлэл			150600.00	150600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			6146900.00	6146900.00
2105	Нормативт зардал	0.00	0.00	18055900.00	18055900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			67000.00	67000.00
210502	Хоол, хүнс			9900000.00	9900000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			8088900.00	8088900.00
2107	Томилголт, зочны зардал	0.00	0.00	669600.00	669600.00
210701	Гадаад албан томилолт			669600.00	
210702	Дотоод албан томилолт				669600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	0.00	251200.00	251200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			251200.00	251200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	4134700.00	4134700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			4134700.00	4134700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	91751700.00	90884500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	82061700.00	81194500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			82061700.00	81194500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	9690000.00	9690000.00
132001	Орон нутгийн төсвөөс			9690000.00	9690000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				2.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага			1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	33.00	35.00
620001	Удирдах ажилтан			1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан			20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан			12.00	14.00
63	СУРАЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.00	0.00	200.00	200.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	0.00	0.00	200.00	200.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага			200.00	200.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.0	0.0	33.0	35.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)			21.00	21.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)			12.00	14.00



АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо: 2020.02.27

Х.ЖЕНИСБЕК

Огноо: 2019.02.27

Р.БАЯРМАА

Огноо: 2019.02.26